

АГУУЛГА

ОРШИЛ.....	2
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	11
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	18
12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА.....	19

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Термос Хөгжил” ХХК-ний Хэнтий аймгийн Дархан сумын нутагт хэрэгжиж буй “Төмрийн хүдрийг баяжуулах үйлдвэр” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, БОАЖЯ-ны сайдын 2019-10-29-ны №А/618 тушаал “Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэрэг эрх зүйн баримт, материалууд дээр үндэслэн боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж тэднээр хэлэлцүүлсний дараа, жил бүр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага, хүсэлтийг хэрхэн хангасныг нэгтгэн хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлтийн үр дүнгийн тайланг тухайн оны 12-р сард багтаан БОАЖЯ нд ирүүлж, дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардлын хэмжээг батална.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: Төмрийн хүдрийг баяжуулах үйлдвэр

Төслийн зорилго: Жилд 500.0 мян.тн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулан, жилд дунджаар 177.5 мян.тн төмрийн баяжмал, 222.3 тн завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэж, жилд дунджаар 34.54 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл үйл ажиллагааны зардал гаргаж, 38.05 тэрбум төгрөгийн борлуулалт хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Термос Хөгжил” ХХК

Улсын бүртгэлийн дугаар – 9011374131

Регистрийн дугаар - 5647622


Хаяг: Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 12-р хороо, хангайн 20, 761 тоот,

Утас: 99096800, 77096800

Төслийн товч тодорхойлолт

“Термос хөгжил” ХХК нь Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/22 тоот шийдвэрээр олгосон 051033 дугаар газар эзэмших гэрчилгээний дагуу үйл ажиллагаа явуулах эрх авсан.

Төмрийн хүдэрээр ханган нийлүүлэлт хийх уурхай нь үйлдвэрийн хойд талд 1.5 км зайд байна. Баяжуулах үйлдвэрийн анхдагч хүдэр буулгах талбай 100*100.0м хэмжээтэй ба нийт 120.0-150.0 мян.тн хүдэр буулгах багтаамжтай байна. Баяжуулах үйлдвэрийг түүхий эдээр найдвартай хангах зорилгоор түүхий эд буулган жигдрүүлэх талбай дээр баяжуулах үйлдвэрийн 1 сарын хэрэглээ болох 50.0 мян.тн хүдрийн нөөцтэй байхаар төлөвлөж ажиллана.



Зураг 1. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем

Төслийн хүчин чадал, тоног төхөөрөмж

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	500.0 мян.тн/жил 1852.0 тн/хоног 92.6тн/цаг 270 хоног/жил 6480 цаг/жил
Анхдагч хүдрийн ширхэглэл	0-750мм
Анхдагч хүдэр дэх төмрийн агуулга	32.0-33.0%
Хүдэр бэлтгэх технологи	3 шатны бутлалт, 1 шатны шигшилт
Хүдэр баяжуулах технологи	Үндсэн болон 1 шатны цэвэрлэгээний хуурай соронзон баяжуулалт
Хаягдлын хэлбэр	Хуурай

Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж:

- Чичиргээт тэжээгүүр /ZSW1149/
- Хацарт бутлуур /PEF0710/
- Конусан бутлуур /PYS-B1324/
- Конусан бутлуур /PYS-D0910/

- Чичиргээт шигшүүр /SZZ2200*6000/
- Соронзон сепаратор/СТВ1218/
- Соронзон сепаратор /СТВ1021/

Баяжуулах үйлдвэрийн цахилгаан хангамж

Баяжуулах үйлдвэрийн хэрэглэх цахилгаан эрчим хүчний үүсвэрээр Зүүн, Өмнөд бүсийн Чойр-Бор-Өндөр чиглэлийн төвлөрсөн цахилгаан хангамжийн Бор-Өндөрийн уурхай дахь 110/35/6 кВ-ын хүчний трансформаторын 35 кВ-ын хүчдэлийг үүсгүүр болгон авч төсөлд тусгасан байна.

Баяжуулах үйлдвэрийн усан хангамж

Усны гол хэрэглэгчид нь үйлдвэрийн тээврийн зорчих хэсгийн зам, ажилчдын унд ахуй, ногоон байгууламжийн усалгаа юм. Баяжуулах үйлдвэр нь талбай дотроо гүний худагтай бөгөөд усны ерөнхий химийг шинжлүүлэхэд химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018”-ын шаардлага хангасан байна.

Төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар боловсруулахад технологийн зориулалтаар ус ашиглахгүй ба унд, ахуй, замын тоосжилт дарах, биологийн нөхөн сэргээлтэд ус ашиглана. Усан хангамжийн эх үүсвэр нь үйлдвэр дотрох гүний худаг байна.

Ажиллах хүч

Баяжуулах үйлдвэрийн ажилчдын материаллаг сонирхлын өндөрсгөх, ажиллагсдыг тоог нэмэгдүүлж, хөдөлмөрийн болон үйлдвэрлэлийн сахилга батыг бэхжүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж байна. Үйлдвэрийн ажиллах онцлог, ажлын нягтралыг харгалзан үзэж нийт 48 хүн ажиллана.


2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн талбайн байршил

Хэнтий аймгийн Дархан сумын 2-р багийн нутагт орших “Термос хөгжил” ХХК–ний Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр нь Улаанбаатар хотоос 300 км, Хэнтий аймгийн Дархан сумаас баруун урагш 35 км, Бор-өндөр сумаас баруун хойш 20 км зайд оршиж байна.

Хүснэгт 1. Эзэмшил газрын координат

№	X	Y
1	109°16'53"E	46°19'01"N
2	109°17'04"E	46°18'53"N
3	109°17'18"E	46°18'53"N
4	109°17'11"E	46°19'07"N



Зураг 1.Төслийн 1:10000 масштабтай байрзүйн зураг

Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт

“Термос Хөгжил” ХХК-ний “Төмрийн хүдрийг баяжуулах үйлдвэр” төслийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолтын хураангуйг энэ хэсэгт оруулав.

Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт	
Физик газарзүйн онцлог	Байгалийн бүс бүслүүрээр хээрийн хуурайвтар хээрийн бүсэд хамаарах ба физик газарзүйн мужлалаар Монголын дорнод талын их мужийн Халхын дундад ба Дарьгангийн талархаг муж - Халхын дундад ухаа гүвээт тал тойрогт хамаарна. Тус сумын газрын гадарга нь далайн төвшингөөс дээш 1148.1-1715 метрт өргөгдсөн. Газрын гадаргын хувьд намхан ухаа, гүвээтэй тал нутаг зонхилох ба нийт нутгийн гадаргын байдлаар нь: Уулархаг гадарга, Нам уулсуудын хоорондох тэгш тал, Хөндийн тэгш гадаргууд гэж ангилна. Төслийн талбай орчим нам уулс ухаа гүвээ, тал хөндий ээлжлэн орших ба далайн төвшнөөс дээш үнэмлэхүй өндөршил 1465-1520 метр байна.
Уур амьсгалын нөхцөл	Хэнтий аймгийн хувьд агаарын температурын жилийн дундаж 1,1°C байв. Агаарын температурын жилийн дундажыг бүс нутгаар нь авч үзвэл: Нутгийн хойд хэсгээр -1,2...+1,8°C, төвийн хэсгээр -0,5... +2,6°C, өмнөд хэсгээр +2,2... +2,7°C байлаа. Агаарын температурын жилийн дундажын хамгийн дулаан Дархан суманд +2,7°C, хамгийн хүйтэн нь Гурванбаян суманд -1,2 °C хүрсэн байна. Хэнтий аймгийн нийт нутгаар нь агаарын температурын жилийн дундаж утгыг олон жилийн дундажтай (ОЖД) харьцуулбал 0,5 градусаар дулаан байсан ба бүс нутгаар авч үзвэл: нутгийн хойд хэсгээр -1,1... 0,9 °C, Төвийн хэсгээр -0,6... 1,5 °C, Өмнөд хэсгээр 0,0... 1,1 °C-аар дулаан байжээ.
Ус	Төслийн хэрэгцээнд технологт ус ашиглахгүй ба унд ахуй, зам усалгааны усыг өөрийн эзэмшлийн худгаас авна.
Усны чанар	Шинжлүүлсэн дүнгээр гүний худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018”-ын шаардлага хангаж байна.
Хөрс	Төслийн талбайд толгодын чулуурхаг хүрэн хөрс тархсан бөгөөд тус хөрс нь ДТД 1463-1491 м-ын өндөршилтэй 11.8 га талбайд тогтворжсон бөгөөд тэнд 3-р сард хагдарсан ургамлын бүрхэвч 30-40% байна. Хойноос урд зүгт 3,5-4,50 налуутай толгод бүхий газарт чулуурхаг хүрэн хөрс нь “А”, “АВ”, “В1” болон “В2к” гэсэн давхаргаас бүрдсэн бөгөөд “В2к” давхаргын 24-28 см-ын гүнээс карбонат илэрсэн, өөрөөр хэлбэл хөрс доор карбонаттай, давсгүй, үржил шим нь өнгөөр адилхан байна. Ийм учраас хоёр зүсэлтийн хөрсний үе давхаргын зузааныг дунчилж үзэв. Шар шулуунаас доош карбонаттай үе давхарга илэрч байна. толгодын хүрэн хөрсний 14-16 см-ийн гүнд буюу А давхаргад ялзмагийн хэмжээ 1,81-1,91%, АВ давхаргад 1,55-1,89%, В давхаргад 0,47-0,91% байна. Тус хөрсний үржил шимт давхаргын дундаж зузаан (А ба АВ) 26 см байж ялзмагийн хэмжээ дунджаар 1.8% байна. Энэхүү үзүүлэлт нь Монголын хээрийн бүсийн толгодын хүрэн хөрсний дундаж үзүүлэлттэй ойролцоо байна. Уусмалын орчин (pH) 0-26 см-ийн гүнд 8,4-8,5 буюу шүлтлэг орчинтой, дээд давхаргад давсжилт байхгүй, гэхдээ В2 давхарга буюу 40-60 см-т карбонаттай.
Ургамал орчин	Төслийн талбайн ургамлан бүлгэмдэл, төрөл зүйлийн жагсаалт, тусгагын бүрхэц болон арвийг тодорхойлох зорилготойгоор 4 цэгт ургамлын бичиглэл үйлдсэн бөгөөд тухайн бүлгэмдэлд 10 овогт хамаарах 25 төрлийн 36 зүйл ургамал тохиолдож байна. Ургамалжил, хөрсний хэвшинжийн хувьд цөлөрхөг хээрийн болон хээрийн завсрын хэвшинжид хамаарах бөгөөд тачирхан сийрэг ургамалтай, харгана бүхий үетэн- Крыловын хялганат хээрийн ургамалжил зонхилон тархана. Хээрийн ургамалжлын үндсэн төрхийг илэрхийлэгч сөөг: Улаан Харгана (<i>Caragana leucophloea</i>) болон жижиг дэгнүүлт үетнүүд: Крыловын Хялгана (<i>Stipa Krylovii</i>), Дэрвээн Хазааргана (<i>Cleistogenes squarrosa</i>) бүлгэмдэлд зонхилгогч, дэд зонхилогчийн, харин Улаан Харгана (<i>Caragana leucophloea</i>) үүрэг оролцоотой байна. Хээрийн Улаан Харгана (<i>Caragana leucophloea</i>)-т цөлжүү хээр Дорнод говийн хойд хэсгээр голлон тархдаг (Санчир, 2011) тухай онцлон дурьдсан байдаг. Энэ зүй тогтол төслийн талбайн ургамалжилд ажиглагдаж байна.
Амьтан	Өөрсдийн судалгааны дүн, амьтан судлаачдын бүтээлд тэмдэглэсэн зүйл зэргийг нэгтгэн тус нутагт 3 зүйл мөлхөгч, 26 зүйл шувуу, 18 зүйл хөхтөн амьтан тэмдэглэлээ. Энэ нутагт хээрийн бүсэд дасан зохицсон амьтад амьдарч байна.

Нийгэм эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт

Нийгэм эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт	
Ерөнхий мэдээлэл	Дархан сум нь 1956 оны 8-р сарын 1-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Баянмөнх сумтай нийлж, 1957 оны 8-р сарын 1-нд дахин бие даасан сум болон байгуулагджээ. Одоо Дархан сум нь засаг захиргааны 5 багтай, 2000 орчим хүн амтай, 189759 толгой малтай , 445482 га буюу 4454,8 км2 нутаг дэвсгэртэй. Нутаг дэвсгэрийн хэмжээгээр аймгийнхаа 17 сумаас 7-р байранд ордог. Энэ нь аймгийн нутаг дэвсгэрийн 4,41%-ийг, Монгол Улсын нутаг дэвсгэрийн 0,28%-ийг тус тус эзэлдэг. Бор-Өндөрөөс 35 кв-ын цахилгаан дамжуулах шугамаар төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. Улаанбаатар-Чойр, Замын Үүдийн мянганы хатуу хучилттай зам нь нутгийн баруун талаар 100 км-ын зайтай өнгөрдөг.
Харилцаа холбоо	Баяжуулах үйлдвэрийн ойролцоох төв суурин газрууд нь харилцаа холбоо өндөр хөгжсөн бүсэд хамаардаг. Үйлдвэр дээр үүрэн телефоны үндэсний байгууллага болох Мобиком,Юнител, Жи Мобайл зэрэг сүлжээ ажилладаг.
Зам тээвэр	Баргилт-Овоогийн уурхайгаас баяжуулах үйлдвэр хүртэл ердийн, орон нутгийн чанартай замаар холбогдсон ба тус уурхайгаас баяжуулах үйлдвэр хүртэл 1,5 км байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Агаарын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд

- Хүдрийг ачиж буулгах, тээвэрлэх, овоолго хийх зэрэг технологийн үйл ажиллагааны явцад тоосжилт үүсэх.
- Хүнд даацын тээврийн хэрэгсэл болон бусад дотоод шаталтат хөдөлгүүр бүхий тоног төхөөрөмж.

Усны чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд

- Байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас хөрсөнд нэвчин бохирдуулах.
- Ахуйн хаягдал бохир ус санамсаргүй байдлаар алдагдах.

Хөрсний чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд

- Тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан хөрс бохирдох.
- Хатуу хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.
- Борооны усны угаагдал, үерийн усны улмаас бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.

Гол сөрөг нөлөөлөл болон нөлөөллийг бууруулах арга зам

Хүснэгт 2. Төслийн голлох сөрөг нөлөөлөл

Бүрэлдэх үүн хэсгүүд	Эх үүсвэр	Нөлөөллийн өртөлтийн хэлбэр	Сэргийлэх арга
Агаар	<ul style="list-style-type: none"> • Хүдрийг ачиж буулгах, тээвэрлэх, овоолго хийх зэрэг технологийн үйл ажиллагааны явцад тоосжилт үүсэх • Хүнд даацын тээврийн хэрэгсэл болон бусад дотоод шаталтат хөдөлгүүр бүхий тоног төхөөрөмж, халаалтын зуухнаас ялгарах утаа 	<ul style="list-style-type: none"> • Агаарт шороо тоос босох • Угаарын хий ялгарах 	<ul style="list-style-type: none"> • Техникийн үзлэг засвар үйлчилгээг тогтмол хийж байх • Тоосжилтоос сэргийлж ногоон байгууламж бий болгох • Хүчтэй салхи шуургатай үед газар шорооны ажлыг хязгаарлах • Зам талбайг тэгшлэх, сул шороог хусч зайлуулах

<p align="center">Усан орчин</p>	<ul style="list-style-type: none"> • Шингэн хаягдал, шатах тослох материалын хаягдлаас • Хог хаягдал хур борооны усаар угаагдан усан орчин бохирдуулах 	<ul style="list-style-type: none"> • ОХШХ-ийг тогтмол хэрэгжүүлэх • Төслийн усны эх үүсвэр болсон гүний худагт эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоож, дэглэмийг мөрдөж ажиллах • улиралд 1 удаа гүний худагт усны шинжилгээ хийлгүүлэх • техник хэрэгслийн тос масло, шатахуун алдагдахгүй байх нөхцлийг бүрдүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Ахуйн бохир усыг түр хадгалах цооногийн бүрэн бүтэн байдал MNS 6561 : 2015 стандартыг хангаж ажиллах • Хур борооны үед төслийн талбайн өндөрлөг хэсэгт 45 градусын налуу 30 см гүнтэй хашааны хойд хэсэг буюу өргөн 98 м, зүүн тал буюу урт нь 175 м, урд хэсэг өргөн 82 м, шуудуу ухаж үерийн уснаас зайлс хийх
<p align="center">Хөрс</p>	<ul style="list-style-type: none"> • Хөрсний элэгдэл, үржил шимийн доройтол • Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарах • Хог хаягдлыг зөвшөөрөлгүй газарт хаях 	<ul style="list-style-type: none"> • Тээврийн хэрэгсэл болон хүний хөдөлгөөнөөс үүсэх хөрсний доройтол • Гал тогооны ахуйн хог хаягдал хөрсөнд алдагсанаар хөрс гадны микро организмуудаар бохирдох • Химийн бодис, тос тосолгооны материал асгарч бохирдох 	<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрийн талбай дахь ахуйн болон, үйлдвэрийн хог хаягдлыг цэвэрлэж, орчныг тохижуулах; • Орчныг бохирдуулахаас хамгаалах; • Гал тогооны ахуйн хог хаягдлыг ангилан ялган нэг цэгт байршуулан хаях бөгөөд хөрсөнд бордоо болоход ашиглах. • Химийн бодис тос тосолгооны материалын хаягдалыг зориулалтын хогийн цэгт хаях, алгарахаас сэргийлэх
<p align="center">Ургамлан бүрхэвч</p>	<ul style="list-style-type: none"> • Төслийн үйл ажиллагааны явцад ургамлан нөмрөг талхлагдах, дарагдах зэргээр зүйлийн бүрдлийн тоо цөөрөх, улмаар устгах 	<ul style="list-style-type: none"> • Тээврийн хэрэгсэл хүний үйл ажиллагаанаас хамааран тоосжилтын нөлөөгөөр ургамлын бүтээмжид сөргөөр нөлөөлөх • Ахуйн хог хаягдал хөрсөнд хаягдсанаар өвчин үүсгэгч микро организмуудаар ургамал өвчлөх 	<ul style="list-style-type: none"> • шатах тослох материал, машин механизмын засварын газар болон ажилчдын тосгоны газрыг эмх цэгцтэй зохион байгуулах • Ногоон байгууламж бий болгох, ногоон байгууламжыг услах, үйлдвэрийн талбайг чийгшүүлэх
<p align="center">Амьтны аймаг</p>	<ul style="list-style-type: none"> • Жижиг мэрэгч, шувуу, бичил биетэн зэрэг амьтад дайжих, устаж үгүй болох 	<ul style="list-style-type: none"> • Төслийн талбайн ойр орчинд хүдэр ачих, зөөх буулгах зэрэг техник, хэрэгслийн хөдөлгөөн, дуу чимээ ихэссэнээс 	<ul style="list-style-type: none"> • хууль бус агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад анхаарах
<p align="center">Хог хаягдал</p>	<ul style="list-style-type: none"> • Ахуйн болон аюултай хог хаягдал 	<ul style="list-style-type: none"> • Ил задгай ангилан ялгахгүй хаяснаар гарах үр дагвар нь орчин бохирдох хөрсөнд бохирдол шингэх агаарт эвгүй үнэр тархах 	<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлыг дахин ашиглах, зөв устгах зайлуулах боломж олгох, 3-4 төрөлд ангилсан цэг байрлуулах • Шатах тослох материал мэргэжлийн байгуулагатай гэрээ хийж зайлуулах

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчин бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах үндсэн зорилготой.

Тус баяжуулах үйлдвэрийн төслийн БОННУ-д тусгасан Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах хууль, эрхзүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зүйл, заалтууд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын холбогдох шаардлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, тэдгээр эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллана.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэнэтийн осол эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүрээлэн буй орчин болоод нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж болох бүх талын арга хэмжээг авч эрүүл аюулгүй, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлж ажиллана. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамарсан.

Тус төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны орон зай, цаг хугацааг бүрэн хамарсан байхаас гадна байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээ зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгасан. Тухайн жилийн БОМТ-ний нийт төсөвт 9 107 000 сая.төг зарцуулахаар төлөвлөсөн.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Агаарын бохирдлоос хамгаалах ажил									
1	Хүдэр болон ачиж буулгах, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх	Зам талбайг услах	Хүдрийн талбайн овоолго		Дотоод төлөвлөлтөөр			2024	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн Ерөнхий шаардлага
2	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс агаар дахь тоосны хэмжээ ихсэх	Тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах тэмдэг байршуулах, тогтсон нэг замаар зорчих шинэ зам үүсгэхгүй байх	Дотоод зам		400,000			2024	MNS:4596:2007 Замын тэмдэг, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх журам
3	Утаа болон хийн бохирдол үүсэх	Агаарын бохирдлын тухай хуулийн дагуу техник хэрэгслийн татварыг төлөх	Ашиглагдах тээврийн хэрэгсэл		Дотоод төлөвлөлтөөр			2024	Дизель хөдөлгүүртэй авто машин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
2. Хөрсний бохирдлоос хамгаалах ажил									
1	Үйлдвэрийн барилга байгууламж, зам талбай доорх хөрс,	Боломжит хэсгүүдэд ногоон байгууламж, тохижилтын ажил хийх, сайжруулах	Үйлдвэрийн кенп орчим		Нөхөн сэргээлтн төлөвлөгөөнд тусгасан			2024	

**“Термос Хөгжил” ХХК-ний Хэнтий аймгийн Дархан сумын нутагт хэрэгжиж буй
“Төмрийн хүдрийг баяжуулах үйлдвэр” төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль
орчны менежментийн төлөвлөгөө**

2024

	газрын гадарга элэгдэлд өртөх					
2	Шатах тослох материалын хаягдлаар хөрс бохирдох	Засварын газрын талбайг хатуу хучилттай болгох	Засварын газар	1,000,000	2024	
3	Олон салаа шороон зам үүсэхээс хамгаалж замын маршрут чиглэл заасан тэмдэг тэмдэглэгээ тавих	Барьгилт овоо уурхайгаас үйлдвэр хүртлэх 1.5 км зам болон бүтээгдэхүүн тээврийн замын дагууд	Тээврийн зам	Дотоод төлөвлөлтөөр	2024	
3. Усан орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах						
1	Хур бороо, үерын усаар төслийн талбай дахь хог хаягдал, шатах тослох материалын үлдэгдэл угаагдан хөрсөнд нэвчиж улмаар газрын доорх усны чанар, найрлагад өөрчлөлт оруулж бохирдуулах	Шатах тослох материал алдагдаж асгарсан тохиолдолд ашиглах шаардагдах хэрэгсэл, материалыг бэлэн байлгах	Засварын газар орчим	Дотоод төлөвлөлтөөр	2024	Хог хаягдлын тухай хууль MNS5916:2008 Хог хаягдлыг ангиллан ялгаж хаях журам
2	Усны шинжилгээг ОХШХ-т заасан хугацаанд хийлгэх		Төслийн талбай	ОХШТ-т тусгасан	2024	
3	Харъяа байгууллагатай ус ашиглах гэрээ байгуулах, төлбөр төлөх	Ус ашиглах боломжит нөөцийн тооцоонд тусгагдсаны дагуу ашиглах		Дотоод төлөвлөлтөөр	2024	
4. Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг багасгах						
1	Амьдрах орчин алдагдах, тоо толгой багасах	Орон нутгийн амьтан хамгаалах үйл ажиллагаанд оролцох		1 000 000	2040	
Нийт				2 400 000		

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ногоон байгууламжыг нэмэгдүүлж агаарын бохирдлыг бууруулах	Ажилчдын суурин орчимд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Цэцгийн мандал, нэг болон олон наст үрт ургамал, мод хөрсний онцлогт тохируулан тарих			1 000 000		2024	
2.	Тэр бум мод хөтөлбөр хэрэгжүүлэх	100 ш мод тарих				500 000		2024	
Нийт						1 500 000			

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Орон нутгаас санал болгосон газарт санал болгосон нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжиж буй талбай, ойр орчинд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй байна. Цаашид ашиглалтын явцад түүх, соёлын өвтэй холбоотой олдвор, дурсгал илэрсэн тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Үйлдвэрийн ажлын явц дахь гэнтийн осол	Анхны тусламжийн иж бүрдэл хүрэлцээтэй хэмжээгээр бэлтгэх	Төслийн талбай		Дотоод төлөвлөлтөөр		2024	
		ХАБЭА-н сургалтуудыг тогтмол зохион байгуулах			ХАБЭА-н төлөвлөгөө		2024	
		ШТМ асгаралтын үед ашиглах шингээгч материал	Засварын цэг		Дотоод төлөвлөлтөөр		2024	
2.	Болзошгүй гал түймэр	Галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх журам боловсруулж, мөрдөж ажиллах	Төслийн талбай		Зохих журмын дагуу		2024	
		Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл хүрэлцээтэй хэмжээгээр байрлуулах, галын хорны даралт, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах						
Нийт		ХАБЭА-н зардал						

10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлыг лонх, лааз, цаас, хоолны үлдэгдэл, бусад гэсэн байдлаар нь ангилан хадгалж дахин ашиглагдах хэсгийг нь хоёрдогч түүхий эдийн цэгт нийлүүлэн, үлдэх буюу ашиглагдахгүй хэсгийг хогийн цэгт зайлуулах нь зүйтэй. Ийнхүү хог хаягдлын төлөвлөгөөг гаргахдаа үйлдвэрийн бүхий л үйл ажиллагааны явцад гарч байгаа хог хаягдлын судалгааны үндсэн дээр боловсруулав.

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн	Ахуйн хог хаягдлыг орон нутгаас заасан цэгт тээвэрлэн зайлуулах	Төслийн талбай	Дотоод төлөвлөлтөөр				2024	Хог хаягдлын тухай хууль, ангилан ялгаж хаях журам, дотоод дүрэм журам
	Хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөр хураамжийг цаг тухайд нь төлөх		2 007 000					
	Хог хаягдлын цэг болон бохирын цооногт ариутгал, халдваргүйжүүлэлт хийх		100 000					
	Хатуу хог хаягдал ангилан ялгах сав, самбар тэмдэг		600 000					
Аюултай	Ашигласан тос масло химийн бодисын үлдэгдэлийг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж зайлуулах		Гэрээний дүнгээр				2024	
Нийт					2 607 000			

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, арга, аргачлал
Хөрсний хяналт шинжилгээний хөтөлбөр				
1.	Хөрсөн дэх хүнд металл	Хяналтын цэгт	Жилд 2 удаа	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 :2008
Агаарын хяналт шинжилгээний хөтөлбөр				
3.	Агаар дахь тоосжилтийн агууламж	Хяналтын цэгт	Жилд 2 удаа	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.
Усны хяналт шинжилгээний хөтөлбөр				
4.	Усны химийн үзүүлэлт	Гүний худгаас	Улиралд 1 удаа	MNS 0900:2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ
5.	Бохир усны үзүүлэлтүүд	Ажилчдын хотхон		MNS 6561:2011 ариутгах татуургад нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага.
Нийт			2 000 000	

12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
1	Газар, ус, агаар бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулах	Жилийн эцэст төлж барагдуулсан байх	Гүйцэтгэх захирал, Ня-бо
2	Ажилчдад байгаль орчны сургалт зохион байгуулах	Дотоод төлөвлөлтөөр	Байгалт орчны мэргэжилтэн

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан
1.	Багийн ИНХ-д	Цахим тайлан	2024 оны БОМТ болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажил	2024 он	200 000	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн болон төслийн удирдагч
2.	ЗДТГ-т	Бичгэн тайлан		2024 он	200 000	
3.	БОАЖЯ-нд			2024 он	200 000	
Нийт					600 000	

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

Урьдчилсан байдлаар тооцож үзэхэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд нэг жилд нийт **10 500 000** төгрөг зарцуулах тооцоо гарч байна. Энэхүү хэмжээ нь тухайн жилээс хамааран өөрчлөгдөж болно.

Менежментийн төлөвлөгөө	Зардлын хэмжээ
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2 400 000
Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1 500 000
Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	-
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2 607 000
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2 000 000
Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	-
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	600 000
Нийт дүн	9 107 000

Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хүрээнд боловсруулагдсан энэхүү тайланд төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах, байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

